

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БГ	Боловсролын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА

2025.02.25 № 86

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг □онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайланд онд Дархан-Уул аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Дархан сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь тус салбар зөвлөлийн жилийн төлөвлөгөөгөө 100 хувь биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 279,938.3 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 62.9 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүлэг 13 зорилтын хүрээнд 93 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.5 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,961,400.00	8,596,828.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банканд байгаа бэлэн мөнгө		
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА		
335	Бусад авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	5,961,400.00	8,596,828.00
354	Хангамжийн материал	5,961,400.00	8,596,828.00
35410	Бичиг хэргийн материал	334,100.00	958,500.00
35420	Аж ахуйн материал	4,048,800.00	5,799,828.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,080,000.00	1,080,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	260,000.00
35470	Бусад хангамжийн материал	498,500.00	498,500.00
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,325,727.70	55,344,335.96
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,325,727.70	55,344,335.96
392	Биет хөрөнгө	18,325,727.70	55,344,335.96
39203	Авто тээврийн хэрэгсэл	18,800,000.00	18,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,800,000.00)	(18,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,505,800.00	47,305,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,993,164.34)	(13,863,203.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,033,936.00	43,033,131.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,220,843.96)	(21,131,391.12)
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,287,127.70	63,941,163.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,287,127.70	63,941,163.96
51	Засгийн газрын хувь оролцоо	24,287,127.70	63,941,163.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,784,909.00	14,784,909.00
51101	Өмч: - төрийн	14,784,909.00	14,784,909.00
512	Хуримтлагдсан үр дүн	9,502,218.70	49,156,254.96
51210	Өмнөх үеийн үр дүн	17,897,407.02	9,502,218.70
51220	Тайлант үеийн үр дүн	(8,395,188.32)	39,654,036.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,287,127.70	63,941,163.96




2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	580,361,400.00	835,298,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	580,361,400.00	835,298,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,400,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,400,000.00	20,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	560,961,400.00	815,298,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	560,961,400.00	815,298,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	588,756,588.32	795,643,963.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,756,588.32	795,643,963.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,120,021.14	378,217,242.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,864,914.50	279,938,250.81
210101	Үндсэн цалин	64,658,960.57	86,390,925.12
210102	Нэмэгдэл	29,895,501.65	64,521,530.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,395,000.00	8,500,200.00
210104	Урамшуулал	51,197,779.48	73,051,432.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,717,672.80	47,474,163.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,626,289.65	31,682,147.82
210201	Тэтгэврийн даатгал	14,371,602.28	22,459,093.33
210202	Тэтгэмжийн даатгал	1,680,722.74	2,631,095.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,345,035.82	1,315,548.57
210204	Ажилгүйдлийн даатгал	302,913.42	970,495.08
210205	Эрүүл мэндийн даатгал	2,926,015.39	4,305,914.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
210304	байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	9,893,770.67	9,308,158.14
210401	Бичиг хэрэг	2,794,100.00	2,059,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,164,300.00	5,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	862,870.67	746,058.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,072,500.00	1,203,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,295,000.00	9,995,041.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,125,000.00	0.00
210604	Урсгал засвар	170,000.00	9,995,041.00

ХТ05430 @ 0022869

2107	Томилолт, зочны зардал	2,080,000.00	3,768,000.00
210702	Дотоод албан томилолт	2,080,000.00	3,768,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,395,258.00	7,399,858.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,236,300.00	5,665,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	742,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,958.00	56,958.00
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	0.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	655,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,964,788.32	36,125,786.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,757,820.00	28,909,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,175,000.00	4,436,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,031,968.32	2,780,586.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,636,567.18	417,426,721.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	325,500,000.00	292,581,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	325,500,000.00	292,581,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,690,000.00	99,858,799.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		12,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		16,181,999.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,690,000.00	70,806,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,446,567.18	24,986,921.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,446,567.18	24,986,921.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,395,188.32	39,654,036.26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,395,188.32	39,654,036.26



2104	Хангамж, бараа материал	10,001,870.67	9,995,558.14
210401	Бичиг хэргийн зардал	2,731,200.00	2,432,500.00
210404	Тээвэр шатахуун	5,114,300.00	5,560,000.00
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	862,870.67	746,058.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,293,500.00	1,257,000.00
210408	Бараа материал актальсны зардал	-	-
2106	Эд хогшил урсгал засвар	1,419,000.00	49,994,236.00
210601	Багаж техник хэрэгсэл	685,000.00	20,000,000.00
210602	Тавилга	-	19,999,195.00
210604	Урсгал засвар	734,000.00	9,995,041.00
2107	Томилолт, зочны зардал	2,080,000.00	3,768,000.00
210702	Дотоодын томилолт	2,080,000.00	3,768,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	5,815,758.00	9,274,386.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,656,800.00	7,539,928.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	742,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	280,000.00
210804	тээврийн хэрэгслийн татвар	56,958.00	56,958.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	500,000.00	655,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,702,300.00	33,218,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,527,300.00	28,782,500.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,175,000.00	4,436,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,636,567.18	416,926,721.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	325,500,000.00	298,620,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	325,500,000.00	298,620,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,690,000.00	93,321,799.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	-	16,181,999.70
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	21,690,000.00	64,269,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,446,567.18	24,984,921.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,446,567.18	24,984,921.53
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,365,000.00	-
	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,365,000.00	-
		(2,365,000.00)	-
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны НИЙТ ДҮН
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	14,784,909.00	-	17,897,407.02	-	32,682,316.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,784,909.00	-	17,897,407.02	-	32,682,316.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн					
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,784,909.00	-	9,502,218.70	-	(8,395,188.32)
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,784,909.00	-	9,502,218.70	-	24,287,127.70
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D07	Тайлант үеийн үр дүн					
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,784,909.00	-	49,156,254.96	-	63,941,163.96




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	815,298,000.00	790,313,078.47	(24,984,921.53)	96.9%
21	Урсгал зардлын дүн	815,298,000.00	790,313,078.47	(24,984,921.53)	96.9%
210	Бараа үйлчилгээний зардал	423,356,000.00	398,371,278.77	(24,984,721.23)	94.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,373,000.00	280,323,061.03	(19,049,938.97)	93.6%
210101	Үндсэн цалин	111,393,200.00	97,866,451.20	(13,526,748.80)	87.9%
210102	Нэмэгдэл	88,681,900.00	85,143,933.26	(3,537,966.74)	96.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,389,000.00	8,345,746.36	3,956,746.36	190.2%
210104	Урамшуулал	79,068,900.00	73,126,930.21	(5,941,969.79)	92.5%
210105	Гэрээт ажлын хөлс	15,840,000.00	15,840,000.00	-	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,421,700.00	31,797,337.60	(5,624,362.40)	85.0%
210201	Тэтгэврийн даатгал	25,446,700.00	22,522,025.80	(2,924,674.20)	88.5%
210202	Тэтгэмжийн даатгал	2,993,700.00	2,631,096.12	(362,603.88)	87.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,496,900.00	1,315,547.57	(181,352.43)	87.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,496,900.00	970,495.75	(526,404.25)	64.8%
210205	ЭМД-ын хураамж	5,987,500.00	4,358,172.36	(1,629,327.64)	72.8%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	9,440,400.00	9,345,558.14	(94,841.86)	99.0%
210401	Бичиг хэрэг	1,781,200.00	2,282,500.00	501,300.00	128.1%
210402	Тээвэр шатахуун	5,065,300.00	5,060,000.00	(5,300.00)	99.9%
210403	Шуудан холбоо	1,300,000.00	746,058.14	(553,941.86)	57.4%
210404	Ном	-	-	-	0.0%
210405	Хог хаягдал	-	-	-	0.0%
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,293,900.00	1,257,000.00	(36,900.00)	97.1%
2105	Нормативт зардал	-	-	-	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,000,000.00	49,994,236.00	(5,764.00)	99.9%
210601	Багаж хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00	-	100.0%
210602	Тавилга	20,000,000.00	19,999,195.00	(805.00)	99.9%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	-	-	-
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,995,041.00	(4,959.00)	99.9%
2107	Томилолт, зочны зардал	3,800,000.00	3,768,000.00	(32,000.00)	99.2%
210702	Дотоод томилолт	3,800,000.00	3,768,000.00	(32,000.00)	99.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	9,330,900.00	9,274,386.00	(56,514.00)	99.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	7,547,600.00	7,539,928.00	(7,672.00)	99.9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	742,500.00	742,500.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	280,000.00	-	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,400.00	56,958.00	(6,442.00)	89.8%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,000.00	-	(42,000.00)	0.0%
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	655,400.00	655,000.00	(400.00)	99.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,990,000.00	13,868,700.00	(121,300.00)	99.1%

ХТЭБЭЭДЭЭ


210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,490,000.00	9,432,500.00	(57,500.00)	99.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,436,200.00	(63,800.00)	98.6%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	391,942,000.00	391,941,799.70	(200.30)	99.9%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	298,620,000.00	298,620,000.00	-	100.0%
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг	298,620,000.00	298,620,000.00	-	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,322,000.00	93,321,799.70	(200.30)	99.9%
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	12,870,000.00	12,870,000.00	-	100.0%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,182,000.00	16,181,999.70	(0.30)	99.9%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	64,270,000.00	64,269,800.00	(200.00)	99.9%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг				
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг				
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр				
	Тоног төхөөрөмж				
	Бусад хөрөнгө				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	815,298,000.00	790,313,078.47	(24,984,921.53)	96.9%
132001	Орон нутгийн төсвөөс	815,298,000.00	790,313,078.47	(24,984,921.53)	96.9%
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.00	5.00	-	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	-	100.00
	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00



2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	20,000,000.00	20,000,000.00	-	100%
21	Урсгал зардлын дүн	20,000,000.00	20,000,000.00	-	100%
210	Бараа үйлчилгээний зардал	20,000,000.00	20,000,000.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	650,000.00	650,000.00	-	100%
210401	Бичиг хэрэг	150,000.00	150,000.00	-	100%
210402	Тээвэр шатахуун	500,000.00	500,000.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	-	-	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр			-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,350,000.00	19,350,000.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,350,000.00	19,350,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			-	-
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,000,000.00	20,000,000.00	-	100%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000,000.00	20,000,000.00	-	100%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00	-	100%



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ нь 2024 оны сум, багийн өөрөө удирдах ёсны байгууллагын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, , төр иргэний харилцааг дээдэлж, иргэдийн хэрэгцээ шаардлага, оролцоонд тулгуурлан дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах, сум, багийн иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 13 зорилт, 93 ажлыг төлөвлөж, хэрэгжилт 94.5 хувь буюу 4.7 онооны биелэлттэй байна. Ажлаа жил, улирлаар төлөвлөн биелэлтийг нь хангуулж ажилласан.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Зардлын норматив шинэчлэн батлах тухай" 2021 оны А/188 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ" зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын ИТХ-ийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС болон СТОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,654.00 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	5,961.4	8,596.8	2,635.4
Үндсэн хөрөнгө	18,325.7	55,344.3	37,018.6
Нийт хөрөнгө	24,287.1	63,941.1	39,654.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	24,287.1	63,941.1	39,654.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	24,287.1	63,941.1	39,654.0

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 8,596.8 мянган төгрөг болж 2,635.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 17,837.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 15,202.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 55,344.3 мянган төгрөг болж 37,018.6 мянган төгрөгөөр өссөн нь 19,800.0 мянган төгрөг компьютер тоног төхөөрөмж, 19,999.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшил буюу нийт 39,799.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авч 2,780.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 63,941.1 мянган төгрөг болж 39,654 мянган өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 783,298.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 783,298.0 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн захирагчид хүргүүлснээр баталсан байна.

Тайлант онд нийт батлагдсан төсвийг 32,000.0 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийг нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 108,073.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 11,055.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 13,164.8 мянган төгрөг, норматив зардал 8,700 мянган төгрөг, албан томилолт 1,688 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 9,161 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 585,6 мянган төгрөг, төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 815,298.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 815,298.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 790,313.1 мянган төгрөгийг зарцуулж, 24,984.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 790,313.1 мянган төгрөг буюу 96,9 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 24,984.5 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
		Код	Нэр				
1	80101	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,373.0	280,323.1	(19,049.9)	93.6%
2		2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,421.7	31,797.3	(5,624.4)	85.0%
3		2104	Хангамж, бараа материалын зардал	9,440.4	9,345.6	(94.4)	99.0%
4		2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,000.0	49,994.2	(5.8)	100.0%
5		2107	Томилолт, зочны зардал	3,800.0	3,768.0	(32.0)	99.2%
6		2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	9,330.9	9,274.4	(56.5)	99.4%
7		2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,990.0	13,868.7	(121.3)	99.1%
8	80825	2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	298,620.0	298,620.0	-	100.0%
9	80802	213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	12,870.0	12,870.0	-	100.0%
10		213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,182.0	16,182.0	(0.0)	100.0%
11		213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	64,270.0	64,269.8	(0.2)	100.0%
Нийт дүн				815,298.0	790,313.1	(24,984.5)	96.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус ИТХ нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 3 ажилтан, үйлчлэх 1 ажилтан буюу нийт 5 ажилтантайгаар ажиллаж, 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардалд 7,539.9 мянган төгрөг, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 9,432.5 мянган төгрөгийг зарцуулж, тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 20,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, чанарын менежер Э.Эрдэнэбат, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 588,756.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,887.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 19,049.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 5,624.3 мянган төгрөг тус тус хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээнээс 4 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасныг тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд оруулбал зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.12.30-ны өдрийн 390 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-нд зааснаар шатахууны зарцуулж байх 1 зөвлөмж, Сангийн Сайдын 2017 оны “Маягт, заавар батлах тухай” 347 дугаар тушаалыг үндэслэн автомашины дагалдах замын хуудас бөглөж байх тухай 1 актын биелэлтийг шалгахад зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	430.6	1	430.6	100
Акт	1	149.8	1	149.8	100
Нийт дүн	1	580.4	1	580.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,960.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,960.0 мянган төгрөгийн албан шаардлага тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 1,960.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Тайлангийн 4.4.1, 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 1,960.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан байна	1	1,960.0	-	-	1	1,960.0	-	-	-	-	-	-
Дүн	1	1,960.0	-	-	1	1,960.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээнээс 4 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	1	-
Тус ИТХ нь Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	2	-			2	-